

**БОДГАЛЬ ҮНЭЛЭМЖИЙН ХАМСМАЛ УТГЫГ ЯРУУ
ИЛЭРХИЙЛЭХҮЙН ШАЛТГААЦЛАЛ ХЭМЭЭХИЙН УЧИР**

Ж. Баянсан¹

Хэл бол зөвхөн хэрэглэгдэж байхдаа л хэл байдаг (Винокур 1959:31)² учраас түүнийг зөвхөн хэрэглээнийх нь орчин буюу харилцахуйн үүргээр нь танин мэдэж болно гэж үздэг.

Хүний харилцаа бол бидний зайлшгүй хэрэгцээнээс үүдэлтэй гэдэг нь хэн хүнд ойлгомжтой асуудал биз. Хэрэгцээг хамгийн ерөнхийгөөр авч үзвэл, бие махбодын хэрэгцээ, эд юмсын хэрэгцээ, оюун санааны хэрэгцээ гэсэн гуван үндсэн төрөл байна гэж үздэг. Тэгвэл хэлж харилцах гэдэг нь эдгээр олон төрлийн хэрэгцээгээ хангах нэг гол арга байх учиртай болох нь бас ойлгомжтой байх болно.

XX зууны хоёрдугаар хагасаас Оросын хэлшинжлэлд Хэлний сэтгэл судлалын ухааны бие даасан дэг үүсэхдээ хэл бол хүн бие цогцсоороо хийдэг элдэв үйл ажиллагааных нь нэг зүйл (Леонтьев 1969)³ гэж үздэг болсон нь хэлийг судлах шинэ дэг, шинэ үзэл баримтлал болсон байна. Өөрөөр хэлбэл, харилцах гэдэг бол хэлж ярих үйлийг өөртөө багталцуулангаа хүний үйл ажиллагааны зайлшгүй нөхцөл, гарцаагүй үр дүн болдог тийм мөн чанарыг хэлж байна.

Хэл бол тэмдгийн тогтолцоо, бас нийгмийн, бодит үзэгдэл болохын хувьд аман ба бичгийн эх хэлбэрээр хэлж харилцах харилцаанд л өөрийн зохих үүргээ гүйцэтгэдэг байна. Иймд хүний үүсгэн хэрэглэж байгаа элдэв эх (текст) бол бодит ертөнцийг төдийгүй, хүн өөрийгөө нээж таних нэг гол арга болно. Учир нь ертөнцийн юм, үзэгдэл, үйл явдал, үйл байдал, хүний мэдрэхүй, үзэл санаа гээд бүх л төрлийн “ертөнц” текстээр л бүрэн дүүрэн илэрч гарах боломжтой байдаг гэж үздэг болсон байна. Чухам ийм учраас “хэлшинжлэл бол текстийн зарц болж байна” (Степанов 1984)⁴ гэсэн үг гүнзгий утга агуулгатай ажээ.

Хэлний тухай шинжлэх ухаан бол өөрийгөө тоочин тодорхойлж байдаг болохоос биш, өөрөө өөрийгөө тайлан тайлбарлаж чадахгүй байдаг (Абаев 1965)⁵ гэсэн энэ үг их учиртай байна.

¹ МУИС-ийн Монгол хэл, соёлын сургууль.

² Винокур Г.О. Избранные работы по русскому языку. М., 1959

³ Леонтьев А.А. Язык, Речь и Речевая деятельность. М., 1969.

Леонтьев А.А. Теория речевой деятельности. М., 1974.

Леонтьев А.А. Основы психолингвистики. М., СПб., 2003 и др.,

⁴ Степанов Г.В. Вступительная статья // Энциклопедический словарь юного филолога. М., 1984

⁵ Абаев В.И. Скифо-европейские изоглоссы: На стыке Востока и Запада. М., 1965

Хэлний тухайн илэрхийлэл яруу илэрхийлэх чадамжтай байна гэдэг бол хамгийн ерөнхийгөөр хэлбэл, харилцах хэрэгцээндээ зориулж хэлээ ашиглаж, хэрэглэж байгааг хэрэг гэж ойлгож болно.

Иймд аливаа бичил эхийг хамгийн оновчтой найруулж чадсанаар уг эхээр олон тооны мэдээллийг илэрхийлж болдог байна. Ингэхдээ хоёр үндсэн зорилгыг агуулж байдаг ажээ. Үүнд:

- Өгүүлэгч этгээд ямар нэг зүйлд сэтгэл хөдөлж, улмаар түүнд эгдүүцэж дургүйцэх ч юмуу, эсвэл ойшоон таашаах хандамжтай болсныгоо илэрхийлэх;
- Энэ харьцаа хандлага, үнэлэмжээ сонсогч/уншигчид “халдаах”(Телия 1991)⁶ гэсэн зорилгоор хэрэглэдэг ажээ.

Ийм учраас хэлний илэрхийлэл болгоны энэхүү яруу илэрхийлэх үүргийг шинжлэн судалж байгаа бол өгүүлэгчийн тал, сонсогчийн тал гэсэн хоёр хүчин зүйлийг заавал харгалзаж үзэх учиртай болдог байна. Чингээд өгүүлэгчийн сэтгэл хөдлөлийн байдлыг сонсогч тэр чигээр нь мэдэрч ч болно, үгүй ч болно. Өөрөөр хэлбэл, тэдний нас бие, сэтгэц сэтгэхүйн онцлог, амьдралын мэдлэг туршлага зэргээсээ хамаараад нэг юм, үзэгдэл, үйл явдал, нөхцөл байдлыг өөр өөрөөр хүлээн авах боломжтой байхаас өөр аргагүй юм.

Ямар нэгэн эхэд өгүүлж байгаа утга санааны зарим нь ил, зарим нь далд илэрсэн байдаг. Далд илрэх мэдээлэл ч гэсэн өөрийн гэсэн зохистой арга хэрэглүүртэй байж, харилцагчийн дотоод санаанаас үүдсэн тодорхой зорилгод захирагдсан байна. Өгүүлж байгаа зүйлийнхээ агуулга, түүний тухай үнэлэмж хандамжаараа дамжуулж сонсогчийн сэтгэлийг хөндөх тандах гэсэн нэг дотоод зорилго заавал байх бөгөөд түүнийг тухайн харилцаа үүсэх шалтгаан гэж үзэж болно. Харин ийнхүү нөлөөлөх хэмээсэн шалтгааны нь нөхцөлдүүлж байгаа боломж буюу арга хэрэглүүрийг тухай харилцааны үүргийг илэрхийлж байгаа утга гэж хэлж болох юм. Жишээлбэл, урьдаас муу явдал хийж, зэвүүцүүлж байдаг нэгэн этгээдэд туйлаас эгдүүцэн дургүйцэж байгаагаа зориуд илэрхийлэхийн тулд “Би түүнийг үзэн ядаж байна” гэж хэлжээ гэж бодоход энэ илэрхийлэл нь уг өгүүлэгчийн “дургүйцсэн” харьцаа хандамжийг ерийн илэрхийлсэн болохоос биш, уран яруу илэрхийлэл биш юм. Харин энэ санааг “Чи ёстой нэг Жамух юм даа” гэсэн бол “Монголын нууц товчоо”-д гардаг, Чингисээс урван тэрсэлж, муу санаалсан нэгэн баатрын дүр, хэрэг явдалтай авалцан холбогдвол сая яруу илэрхийлэх үүрэгтэй болно.

Ингэхлээр “Би түүнийг үзэн ядаж байна”. “Чи ёстой нэг Жамух юм даа” гэсэн энэ хоёр өгүүлбэр *ямар нэгэн этгээдэд ихэд дургүйцэж байгаа* санааг илэрхийлэхийг зорьсноороо ижил илэрхийлэл болно. Нөгөө талаар, уг илэрхийлэлд гарч байгаа юм (Жамух) нь бас нэг өвөрмөц мэдээлэл агуулдаг байна. Гагцхүү яруу илэрхийлэх чадамжаараа ялгаатай юм. Өөрөөр хэлбэл, хоёрдох өгүүлбэрт “үзэн ядаж байгаа” тухай мэдээлэл шууд илрээгүй ч гэсэн “Монголын нууц товчоо”-ны агуулгыг сайн мэдэх олонхид Жамухыг урвагч хэмээн үзэж болдог нэгэн өгүүлэмжтэй утга санаа авалцан холбогдсоноос болоод энэ “үзэн ядах” санаа илрэх боломжтой болдог. Хэрэв Жамухыг Чингисийн үнэнч анд хэмээн үздэг хэн нэгэнд энэ мэдээлэл нь зэвүүцэн дургүйцсэн биш, харин бахархан таашаасан үнэлэмжийн илэрхийлэл болж, өөрөөр тайлагдах

⁶ Телия В.Н. Экспрессивность как проявление субъективного фактора в языке и ее прагматическая ориентация // Человеческий фактор в языке: Языковые механизмы экспрессивности М., 1991

боломжтой ч байж болдогт хэргийн ээдрээ оршиж байгаа билээ. Ийм учраас нэг хэрэг явдлын талаарх өгүүлэгч сонсогчийн үнэлэмж давхцаж ч болно, зөрж ч болно.

Хэлний яруу илэрхийлэх чадамжийг судлахад тулгардаг гол бэрхшээл юунд оршино вэ? гэвэл, яруу илэрхийлэл бол хэлний махбод, түүнийг утга санаандаа нийцүүлэн үүсгэх, улмаар тэр үүсвэрий нь сонсогч хүлээн авч, ойлгож тайлах арга оньсыг ашиглаж хэрэгжихээс өөр аргагүй байдаг боловч хүний сэтгэлийг хөндөх чадамж нь гагцхүү хэлэхүйн төвшинд хэрэгждэг байна. Ийм учраас яруу илэрхийлэл болгоны биежиж байгаа махбод нь үг, холбоо үг, зарим задлаг хам бүтэц, тогтвортой хэллэг байх нь гарцаагүй боловч өгүүлэгчийн сэтгэл хөдлөлийн байдал, түүгээрээ сонсогчийн сэтгэлийг хөндөх гэсэн эрмэлзэл зорилго нь эдгээр материаллаг бүтцийн гадна ч юм шиг, тэгэхдээ бас дотоодод нь, түүнээс ангид илрэх аргагүй байдагт л хэргийн учир оршиж байгаа мэт. Ийм учраас яруу илэрхийлэх чадамжийн энэ хоёр тал буюу утга, үүрэг хоёрыг ялган ойлгож, тодорхойлох хэрэгтэй юм байна. Өөрөөр хэлбэл, өгүүлэгчийн өөрийнх нь сэтгэл хөдлөлийн байдал, түүгээрээ сонсогчийн сэтгэлийг хөндөх гэж зорихдоо ашиглаж хэрэглэсэн арга нь даруй яруу илэрхийлэх үүрэгтэй болж байгааг чухамдаа түүний утга гэж хэлж болох юм.

Хэлж харилцах явцад яруу илэрхийлэл үүсэхдээ санаанд оромгүй зүйлийг бүл цал, барим тавим хэлэх, ер бусын бүтэцтэй үг хэллэг, нийлэмж үүсэх, үгийн наадам болгох, гэнэт сэтгэл сэрдхийм үг яриа гарах, ёжлож тохуурхах, егөөдөж дамшиглах, даажигнаж дээрэлхэх, тавлаж бахаа хангах зэргээр урьдаас таамаглах аргагүй янз бүрийн мэдрэмж үүсдэгээрээ онцлогтой юм.

Иймэрхүү үзэгдэл нь элдэв дүрслэх хэрэглүүр, заримдаа авиа дуурайх, дүрслэх хэрэглүүрээр илэрч байгаа хэлний шалтгаанцмал шинжээс гадна сэтгэлзүйн талаасаа ихээхэн учир холбогдол бүхий өөр бусад арга хэрэглүүр хослон илэрч байгаа гэж үзвэл зохих юм.

SUMMARY

In this article, the author discusses the expression method which is a special category of the phrasal units. The expression method is a phenomenon expressing the speaker's values and emotions, influences directly to the listener's emotional attitude. Therefore, studying the meaning of expression method must have count on the communicational hierarchy of speaker (writer) <=> listener (reader).